

№ 11 / 2020 оны 5 дугаар сар

ЗЭРЛЭГ АМЬТДАА ХАМГААЛСААР БАЙХ БОЛНО!

Говийн их дархан цаазат газар /ГИДЦГ/-ын "Б" хэсэгт сэргээн нутагшуулж буй тахийн сүрэгт 4-р сарын эхээр 2020 оны анхны унага мэндэллээ.



Энэ хавар нийт 77 гүү хээлтэй гэж тодорхойлогдсон нь тахь сэргээн нутагшуулсан хугацааны хамгийн олон гүү хээл авсан жил болж байна.

Photo: Cyril Ruoso.

Тахь адуу, түүний амьдрах орчныг хамгаалах нь

Тахийг хайрлан хамгаалдаг ЭРХЭМ АНДУУДАА,



Дэлхий даяар сүүлийн үед амьдралын олон хэв маяг устсаар байгааг байгаль хамгаалагчдад тайлбарлах шаардлагагүй юм. Амьтдын амьдрах орчны өөрчлөлт, хүмүүсийн хэт хэрэглээ, байгаль орчны бохирдол, хууль бус үйлдэл, ан агнуур, амьтны эрлийжүүлэлт зэрэг нь байгаль орчинд урт хугацааны туршид тулгарч буй аюул заналын нэгээхэн хэсэг нь юм.

Иймэрхүү цаг үед бид бүх анхаарлаа өөртөө төвлөрүүлснээс болж бараг л төөрөлддөг.

Бидний гаргасан санаачилга, хандивлагчдын өгөөмөр сэтгэлээс бүрэн дүүрэн амьдардаг нь эдгээр нөхцөлд говийн цөөрөм/тогтоол ус шиг хурдан хатаж болно. Гэхдээ шаардлагатай санхүүгийн эх үүсвэр байгаа тохиолдолд л ажлаа хийж чадна гэсэн үг бас бидэнд хамаатай.

Байгаль дэлхий өөрөө байнга тахлын шинжтэй байдаг ч байгаль хамгаалах экосистемийг шинэчилж, боловсронгуй болгож байх нь чухал юм. Ялангуяа хэрэгтэй цаг үед байгаль хамгаалах үүрэг хариуцлага илүү өндөр гэдгийг мэддэг хүмүүс олон гэдэгт би итгэлтэй байна. Тийм учраас би байнга эргэх холбоотой байх болно. Та ч бас уу?

Эдгээр нь орчин үед байгалийн баялаг, ашигт малтмал, ан амьтанд сөрөг нөлөө үзүүлж, улмаар мөхөж сөнөх аюул занал учруулж байна.

Энэхүү аюул заналын тусгал нь өнөө үед биднийг түгшээж буй коронавирусийн цар тахал бөгөөд энэ нь хүн амын шигүү суурьшил, орчин үеийн техник технологийн хэт хөгжлөөс хамаарч буйг тодорхой харуулж байна. Энэ вирус нь амьтны түүхий эд, эрхтэн худалдаалдаг Хятадын нэгэн хүнсний захаас эхэлсэн бөгөөд энэ захад зэрлэг амьтдыг амьдаар нь барьж, торонд хорин, ховор амттан болгон зарахыг санал болгодог байна. Энэ үед сарьсан багваахай болон нэн ховордсон панголины төрөл зүйлүүдийн урьд өмнө нь хоорондоо холбогдож байгаагүй коронавирусийн генүүд солилцсон байх магадлалтай. Үүний үр дүнд хүнд маш их халдвартай зооноз өвчин үүсэж, хүн төрөлхтнийг аймшигт сүйрэлд хүргэв.

Байгалийн зүй тогтоц алдагдаж, шинэ төрлийн нян бий болж улмаар хүн төрөлхтөн төдийгүй дэлхий дээрх нэн ховордож буй амьтдыг хамгаалахад аюул занал учруулдаг халдварт өвчний эх үүсвэр болдог ажээ.

Дэлхийн хүн төрөлхтөнтэй харьцуулахад өнөө үед маш олон амьтан ба ургамлын төрөл зүйл нэн ховордож устаж байна. Ялангуяа нэн ховордсон амьтад болох тахь ба зэрлэг адууны хувьд дээрх халдварт өвчин тун аюултай. Ган гачигт өртсөн амьтад халдварын нянг уст цэгээр дамжуулж байна гэж төсөөлөөд үздээ. Зэрлэг амьтдын дунд ихээхэн хэмжээний хохирол учирч болзошгүй тахлын эрсдэл өндөр байна. Иймээс ГИДЦГ-ын "Б" хэсгийн усны нөөцийг шинээр судалж байгаагийн нэг шалтгаан нь энэ юм.

Цар тахал манай нийгэмд ямар хурдан хор уршиг учруулж болохыг тайлбарлах шаардлагагүй. Энэ нь мөн ховордсон амьтдыг ч хүртэл хямралд оруулж байна. Учир нь бидний зөвхөн өөрсөд рүүгээ чиглэсэн сэтгэлгээ нь ердийн цаг үед ч байгаль орчноо хамгаална гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй шүү дээ.

Др. Райнхард Шнидрих, Олон Улсын Тахь Группын Ерөнхийлөгч



Тахийн мэдээ сонин нь ГИДЦГ-ын "Б" хэсгийн орчны бүсэд амьдардаг хүн амын сонирхлыг ч ихээр татдаг.

Дархан цаазат газар нь тэдэнд өгөөжтэй байх ёстой тул Олон улсын тахь групп нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон орон нутгийн удирдлагуудтай нягт хамтран ажилладаг.

Зургийг: Анита Фарни

Өвөрмөц экосистемийг хамгаалах даалгавар нь туйлын хүнд үед ч байсаар байх болно.

Цөлийн усыг хэрхэн ашиглах вэ?

ГИДЦГ-ын “Б” хэсгийн уснаас хамаарал бүхий олон амьтан, ургамал байдаг. Жижиг баянбүрдүүдийн ургамал нь булаг шандыг тойрон ургаснаар амьдралын гол цэг болдог. Түүгээр хооллодог зэрлэг амьтдын хувьд тэр нь үргэлж хязгаарлагдмал байдаг тул өрсөлдөөн бүрийг мэдэрдэг байна. Энэ арвин баян нутаг нь дэлхийн хэмжээнд ховордсон тахь, хулан, хар сүүлт, аргаль, ирвэс зэрэг амьтдын хоргодох газар, олон тооны унаган ургамлын өлгий нутаг төдийгүй нүүдэллэн яваа усны шувуудыг зам зуур амраадаг чухал ач холбогдолтой. Үүнээс гадна энэ нутаг нь бог малын хувьд өвлийн чухал бэлчээр болж байдаг. Иймд говь, цөлийн уснаас манай байгаль хамгаалагчид, тэдний гэр бүл болон байгаль хамгаалах ажил үйлс маань ихээхэн хамааралтай.



Зургийг: Петра Каченский

Говь, цөлийн булаг шанднаас ГИДЦГ-ын “Б” хэсэг утаг болон нүүдэлчин малчдын өвлийн бэлчээр хамаардаг. Баруун талд: Дэрстэйн уст цэг

Уст цэгүүд нь амьтад болон бодьгалууд хоорондоо байнга тааралдах гол цэг болдог. Энд тахь адуутай тааралдаж эрлийзжих аюул байхаас гадна янз бүрийн өвчин эмгэг амархан тархах боломжийг бүрдүүлдэг. Нэмж дурдахад уур амьсгалын өөрчлөлт нь Монгол улсын хилээр хязгаарлагддаггүй. ГИДЦГ-ын “Б” хэсгийн цаг агаар улам л халсаар байгаа нь цаашид илүү ногоон байх уу, цөлжих үү гэдгийг тодорхойгүй болгож, цаг агаарын эрс тэс үзэгдэл илүү түгээмэл болох хандлагатай. Монгол орны усан хангамжийг улам бүр нарийвчлан судалж байгаа боловч маш хуурай газар нутгийн ус зүйг, ялангуяа тусгай хамгаалалттай газар нутагт маш бага судалж, одоо хүртэл хамгаалалтын арга хэмжээ аваагүй байна. Хэрэв энэхүү үржил шимгүй экосистемийг хадгалан хамгаалахыг хүсч байвал юуны түрүүнд цөлийн усанд санаа тавих хэрэгтэй.

Тийм ч учраас Олон улсын тахь групп нь ГИДЦГ-ын “Б” хэсгийн усны менежментийг сайжруулах зорилгоор Монгол дахь Швейцарын хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүжилт бүхий төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү ажлыг Олон улсын тахь группийн Монгол дахь төлөөлөгчийн газрын зохицуулагч Ж. Батсүх удирдан зохион байгуулж байгаа бөгөөд ГИДЦГ-ын “Б” хэсгийн хамгаалалтын захиргаа (Дарга: О. Ганбаатар), Ховдын Их сургууль (Судалгааны удирдагч: Дэд профессор С. Бурмаа), Венийн мал эмнэлгийн ухааны Их сургуулийн Зэрлэг амьтан, экологийн судалгааны хүрээлэнтэй (Доктор П. Каченский) хамтран хэрэгжүүлэх бөгөөд зэрлэг амьтан, малчдын үйл ажиллагаа, ус зүй, аялал жуулчлалын боломж, газар ашиглалт, тусгай хамгаалалттай газрын дэд бүтцийн асуудлаар хэлэлцэх болно.


Энэхүү төслийн хүрээнд ГИДЦГ-ын “Б” хэсэг усны нөөцийн бүртгэл, гидрологийн мэдээллийн сан бүрдүүлэх, химийн болон микробиологийн иж бүрэн дүн шинжилгээ хийх ажээ.

Амьдралыг тэтгэгч ус

Тахь, хулан нь Төв Азийн их газрын хуурай уур амьсгал бүхий орчиндоо сайн зохицсон хэдий ч тэд өдөр бүр ус уух хэрэгтэй. Тахь ихэвчлэн өвслөг, хулан модлог бутлаг ургамлаар хооллох бөгөөд тэдний идэш тэжээлийн ургамал нь газрын доорх ус, хур тунадаснаас үүсэх хөрсний чийгний хангалтаас хамааралтай. Дэлхийн хамгийн алслагдсан энэ нутагт унадаг улирлын чанартай хур тунадас нь жилдээ 100 мм-ээс дээшгүй хэмжээтэй байдаг бөгөөд энэ нь ихэвчлэн зуны улиралд тохиолддог. Үүнийг Швейцар улсын нутагт жилд унадаг хур тунадастай харьцуулахад таваас арван тав дахин бага гэсэн үг. Ус нь хөрсний гадаргууд шингэснээр өвс ногоо ургаж, хоол тэжээлтэй залгадаг ч энэ нь богино хугацаанд л боломжтой бөгөөд удалгүй хатаж гандах болно.

ГИДЦГ-ын “Б” хэсэгт хэд хэдэн байгалийн болон цөөн тооны хүний гараар гаргасан уст цэгүүд байдаг ба тэдгээр нь гол төлөв Хятад улстай залгасан хилийн дагуу сунан тогтсон уул нуруудын бэлүүдэд байрладаг. Дархан цаазат газрын үүн хэсэгт байрлах Хонь ус болон баруун хэсгийн Тахь усны баянбүрдүүд нь жилийн турш ус, бэлчээрээр хангаж байдаг хамгийн чухал хоёр баянбүрд юм.

Тус Дархан цаазат газрын менежментийн төлөвлөгөөнд эдгээр баянбүрдийг биологийн олон янз байдал, заримдаг цөлийн экосистемийг хамгаалахад онцгой ач холбогдолтой гэж тодорхойлжээ.



Зургийг: Сүхбаатарын Далайцэрэн



Зургийг : ГИДЦГ-ын “Б” хэсгийн архиваас

Усны судалгааны мэдээллийг сонины дараагийн дугаарт “Монгол орны байгаль орчин” цувралаараа бусад байгууллагууд болон олон нийтэд нээлттэй харуулах болно. Анхаарах шаардлагатай уст цэгүүд, үүний дотор булаг шандуудыг судалгааны мэдээлэлд үндэслэн тэмдэглэж, хамгаалах ба судалгааны үр дүнд үндэслэн тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах зөвлөмжүүдийг боловсруулан, шаардлагатай тоног төхөөрөмжийг Ховдын Их сургуульд хандивлна.

Энэхүү төсөл нь ГИДЦГ-ын “Б” хэсгийн өндөр түвшний хамгаалалтын статусыг (Олон улсын Байгаль Хамгаалах холбооны ангилал) хангаж, Олон улсын Байгаль Хамгаалах холбооны Улаан жагсаалтад орсон амьтны төрөл зүйлүүдийг хамгаалах санаачлагад дэмжлэг үзүүлэх зорилготой.

Олон улсын тахь групп нь усны менежментийг оновчтой болгох зорилгоор тусгай хамгаалалттай газар нутгийн усны нөөц болон гидрологийн иж бүрэн шинжилгээ хийхээр төлөвлөж байна.

Байгаль хамгааллын талаар Др. Петра Каченский-тэй хийсэн ярилцлага

Говь, талын туруутан амьтдын гурав дахь удаагийн цэгэн тооллогыг ГИДЦГ-ын “Б” хэсэгт намрын эхэн сард хэрэгжүүлэхээр төлөвлөж, шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг Олон улсын тахь групп хайж байгаа бөгөөд энэ ажлыг биологийн ухааны доктор Петра Каченский удирдан ажиллах юм.

Байгаль хамгаалах мэргэжлийн салбартаа дэлхийд танигдсан Др. Петра Каченский нь Олон улсын тахь групп (ОУТГ)-ын судалгааны ажлын тэргүүлэгчээр сонгогдон ажиллаж байна.

ОУТГ: Швейцарын газар нутгийн бараг тал хэмжээтэй нутагт туруутан амьтдын тооллого хийх гэж байгаа нь үнэхээр солиотой ажил шиг сонсогдож байна. Гэхдээ энэ нь боломжтой гэдгийг та хоёр ч удаа нотолсон. Гэхдээ энэ тооллого нь юунд хэрэгтэй юм бэ?

Др. Петра Каченский: Бид үүнийг тусгай хамгаалалттай газар нутагт ажлынхаа зорилгодоо хүрч байгаа эсэхийг шалгахын тулд ашигладаг. Үүнд: Ховордсон зүйлийн тоо толгой хэрхэн өөрчлөгдөж байна? Гэхдээ байгаль хамгааллын энэхүү суурь асуултад энгийн хариулт байдаггүй.

ГИДЦГ-ын “Б” хэсгийн байгаль хамгаалагчид тахь нэг бүрээ таньдаг. Ингэснээр байрлал нь харьцангуй тогтвортой нийт сүргүүдэд найдвартайгаар тоолж чаддаг. Гэхдээ хулан, хар сүүлт, зээрийн сүргүүд илүү том, өргөн уудам нутгаар нүүдэллэдэг тул бүрэн тоолох боломжгүй юм. Иймд тооллогын цогц, системтэй судалгаа шаардлагатай.

ОУТГ: Энэ том нутагтай тусгай хамгаалалттай газарт, ингэж ихээр нүүдэллэдэг амьтдын найдвартай тоог яаж гаргах вэ?

Др. Петра Каченский: Бид энэ талаарх аргачлалыг боловсруулж анх 2010 онд ашиглаж байсан бөгөөд үүнээс хойш улам боловсронгуй болгосноор байна. Тухайн үед бид системчлэн сонгосон 50 ажиглалтын цэгүүдэд нэгэн зэрэг тоолж, дархан цаазат газрын зүүн болон баруун хэсгүүдэд хоёр өдөр дараалан ажиглалт хийсэн. Ажиглалтын цэг бүрт 2 хүн нэг хонож, тогтсон цаг бүрт 6 удаа ажиглалтын цэгийн орчмын бүх туруутан амьтдыг тоолж байсан. Зүүнгарын говийн уудам, ой модгүй тэгш тал нутагт нэгэн зэрэг томоохон хэмжээний газрыг ажиглах боломжтой. Ингэж тусгай хамгаалалттай газар нутагт хулан, хар сүүлтийн сүргийн анхны тооллогыг хэрэгжүүлсэн бөгөөд тухайн зүйлүүдийн популяцын тоо толгойн чиг хандлагыг тодорхойлохын тулд тооллогыг 5 жил тутамд давтаж хийхийг зөвлөсөн. 2015 онд 7 бид ажиглалтын цэгүүдийн тоог 80 болгож, ажиглалтын цэг бүрт 1 ажиглагч тоолохоор болгож өөрчилсөн.

ОУТГ: Үүнээс та бүхэн ямар чиг хандлагыг харсан бэ?

Др. Петра Каченский: Хулангийн тоо толгой жилдээ 13-14 хувиар, хар сүүлтийн тоо толгой жилдээ 18-19 хувиар өссөн нь сайшаалтай. Хулангийн тоог тоолсон цагтаа нягтралыг нь судалж дараа нь нийт талбайд шилжүүлэн бодсон ба бид хулан, хар сүүлтийг нэг бүрчлэн тоолоогүй ч ажиглалт хийсэн 11'000 км² талбайд 5 жилийн дотор ойролцоогоор хулан 5'700-аас 9'300, хар сүүлт зээр 6'000-аас 13'500 орчим болж өссөнийг тогтоосон.

ОУТГ: Байгаль хамгаалагчдын хүчин чармайлт нь эдгээр хоёр зүйлийн тоо толгойн өсөлтөд их амжилттай нөлөөлжээ!

Др. Петра Каченский: Мэдээжийн хэрэг. Гэхдээ 2009, 2010 оны өвөл тохиолдсон маш хүйтэн, цас ихтэй зуднаар олон сая бог мал, мэдээж олон тооны хулан, хар сүүлт зээр, сэргээн нутагшуулсан тахийн бараг гуравны хоёр нь үхэж хорогдсон байсныг давхар тооцоолох хэрэгтэй. 2010-2015 оны хоорондох тоо толгойн огцом өсөлт үүнд нөлөөлсөн байж магадгүй юм. Харин 2015-2020 оны сүүлийн 5 жилийн хандлагыг судлах нь илүү их сонирхолтой байх болно.

ОУТГ: Өнгөрсөн жил Улсын Их хурлын удаан хүлээсэн шийдвэрийн дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ бараг хоёр дахин нэмэгдсэн. Та үүнийг шинээр хийх тооллогын ажилд харгалзан үзсэн үү?



Зэрлэг амьтны биологич Др. Петра Каченский нь Норвегийн Тронхейм хотын Байгалийн судалгааны хүрээлэн болон Вена хотын Мал эмнэлгийн анагаах ухааны Их сургуулийн Зэрлэг амьтан, экологийн судалгааны хүрээлэнд ажилладаг. Тэрээр Редженсбург, Боулдер (Ко), Мюнхен хотуудад шилүүс, хүрэн баавгайн чиглэлийн судалгаагаар суралцан хамгаалсан.

Тэрбээр адууны төрөл зүйлүүд болон том махчин амьтдын экологи, байгаль хамгаалах асуудлаарх олон тооны эрдэм шинжилгээний бүтээлийн зохиогч нь юм.

Др. Петра Каченский: Мэдээжийн хэрэг. ГИДЦГ-ын “Б” хэсгийн туруутны сүүлчийн тооллогын үед бид мөн дархан цаазат газрын хилийн гадна байрлах ажиглалтын цэгүүдийг оруулсан. Хулан болон хар сүүлт нь амьдрах орчноо бүрэн ашиглахын тулд дархан цаазат газрын нутгаас тогтмол гардаг гэдгийг бид мэддэг байсан. Бид мэдээж эдгээр байрлалыг дахин тогтоох болно. Бид дархан цаазат газрын баруун болон зүүн хэсгийн шинээр өргөтгөсөн газруудад нэмж 40 ажиглалтын цэгүүдийг байгуулна. Тооллогын хугацааг 4-өөс 6 хоногоор сунгах болно. Энэ нь хар сүүлтийн тархцын талбайн талаар илүү сайн ойлголттой болох, хулангийн хувьд шинэ эсвэл нэмэлт идээшил нутгийн талаар илүү мэдээлэл олж авах болов уу гэж найдаж байна.

ОУТГ: Та арга зүйдээ нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна уу?

Др. Петра Каченский: Харьцуулахын тулд бид ижил аргыг ашиглах болно. Гэхдээ илүү нарийвчлалтай мэдээллийг авахын тулд агаарын тооллыг нэмж оруулна. Бид Казахстан улсад хулан, хар сүүлтийн тооллого нисдэг төхөөрөмжүүдийг /дронуудыг/ аль хэдийн туршиж үзсэн.

ОУТГ: Үүнийг яаж хийх вэ?

Др. Петра Каченский: Бид дархан цаазат газрын хуучин хилээр баруунаас зүүн зүгт трансектээр 5 км-ийн зайтайгаар 7-10 хоногийн турш нислэг үйлдэнэ. Хоёр зэрэгцээ камер ашиглан трансект бүр 400 м өргөнийг хамруулах болно. Нэг трансект дунджаар 150 км урт байх болно. Мэдээллийг Казахстан улсын Биологийн олон янз байдлыг хамгаалах нийгэмлэгтэй (АСВК) хамтран боловсруулж, тэнд дүн шинжилгээ хийнэ.



Зургийг: ГИДЦГ-ын “Б” хэсгийн архиваас

Үргэмтгий, үргэлж нүүдэллэж байдаг хар сүүлтийг тоолох амаргүй.

1000 тахь ГИДЦГ-ын “Б” хэсэгт?

Нисдэг төхөөрөмжөөр тоолох газар нутгийг өмнөх тооллогын үр дүнд үндэслэн газар дээр нь нягтлан шалгах болно. Нисдэг төхөөрөмж нь илүү нарийвчлалтай, илүү зардал багатай тоолох боломжийг олгодог хэдий ч өндөр нарийвчлалтай камертай, олон цагаар урьдчилан боловсруулсан замын дагуу нисэх чадвар бүхий мэргэжлийн дрон шаардлагатай байдаг. Үүнийг ашигласнаар судалгааны талбайг илүү нарийвчлалтай, түүний дотор хүрэх боломжгүй газрууд, эсвэл ажиглалтын тохиромжтой цэггүй далд газруудыг хамрах боломжтой болно. Дроноор авсан зургийг дараа нь дахин шинжлэх боломжтой бөгөөд амьдрах орон зайн төлөв байдлын өндөр нарийвчлалтай зургуудын мэдээллийн санг бүрдүүлж өгдөг.

ОУТГ: Энэ үйл ажиллагааны зохион байгуулалтыг Та хэрхэн төсөөлж байна вэ?

Др. Петра Каченский: Их өргөн хүрээтэйгээр. Бидэнд ажиглалтын бичлэг хийхэд 44 тоологч, олон улсын 2 судлаач, 5 жолооч/тогооч, 10 тээврийн хэрэгсэл, дрон нисгэх 2 мэргэжилтэн шаардагдана.

ОУТГ: Энэ бүгд нийтдээ 80,000 CHF-ийн төсөвтэй байх болно. Бидний хувьд хандив тусламж хайж байгаа. Та туруутан амьтдын тооллого цар тахлаас үл хамааран төлөвлөсөн байдлаар биелэх боломжтой гэдэгт итгэлтэй байна уу?

Др. Петра Каченский: Үүнийг урьдчилан хэлэхэд хэцүү байна. Аялах хязгаарыг 6-р сарын эцсээр сунгавал 8-р сарын сүүл, 9-р сарын эхээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цэгэн тооллогын ажлыг нэг жилээр хойшлуулах нь зүйтэй. Учир нь говьд намрын адаг сард хээр хоноход тохиромжгүй хүйтэн болсон байдаг.

ОУТГ: Дэлгэрэнгүй мэдээлэл бүхий ярилцлага өгсөнд маш их баярлалаа!



ГИДЦГ-ын “Б” хэсэгт сэргээн нутагшуулж буй тахийн тоог 1000-д хүргэх бидний алсын хараа Монголын агаарын тээврийн МИАТ сэтгүүлийн нүүрэнд гарчээ. Тус сэтгүүл нь Олон Улсын Тахь группын Ерөнхийлөгч Др. Райнхард Шнидрихээс ярилцлага авсан байна.

2020 оны туруутан амьтдын тооллогод тусгай хамгаалалттай газар нутаг дахь системчлэн сонгосон ажиглалтын 40 цэгээс нэгэн зэрэг 2 өртөөлөн тоолох бөгөөд өндөр нарийвчлалтай камертай дронуудыг зэрэг ашиглах болно (Зураг дээр хулангийн сүрэг).

Зургийг: ГИДЦГ-ын “Б” хэсгийн архиваас



21 настай гүү энэ жилийн анхны унагыг гаргалаа!

Нийт 11 тоо толгой тахьтай Ажнай азаргын сүргийн Зур нэртэй гүү нь зэрлэг байгальдаа фото зургаа хамгийн ихээр даруулсан тахь юм. 1999 оны 6-р сарын 6-нд ХБНГУ-ын Кёльн хотын амьтны хүрээлэнд төрсөн Зур нь одоо ч хүнээс үргэдэггүй ба 21 насандаа 4-р сарын эхээр дахин нэг охин унага буюу 2020 оны анхны унагыг төрүүлээ. Хамгаалалтын захиргааны дарга О. Ганбаатар нарын тодорхойлсноор энэ жил 77 гүү (70%) хээл авсан.

Олон улсын тахь группийн дэд ерөнхийлөгч, анхлан тахь тээвэрлэн нутагшуулсан хүмүүсийн нэг Кристиан Штауфферийн төрсөн өдрийн бэлэг нь сүүлийн хоёр жилийн хугацаанд 2 дахь удаагаа тухайн жилийн шинэ төрсөн унага байлаа. Төрсөн өдрийн сар, өдрийг нууц хэвээр үлдээж Зур, түүний төрсөн шинэ унага болон Кристиандаа аз жаргал, хур бороо орохын өлзийтэй ерөөл дэвшүүлье.

Цуут нэг сүргийг булаан авчээ

Тахийн сүрэглэлт нь амьтны хүрээлэнгээс ялгаатай. Энэ явцад байгалийн хатуу ширүүн үзэгдлүүд давтагдан тохиолдох нь сүргийн тоо толгойн өөрчлөлтийн гол шалтгаан болдог. Азаргын хувьд зөвхөн өөрийн сүрэгт хураасан гүүтэйгээ үржилд ордог. Сүрэг хураах нь зүгээр нэг явдал биш шүү. Тахь зэрлэг догшин зан авиртай. Өрсөлдөгч азарга үрээдээс өөрийн хураасан гүү, унага төлөө хүчтэй хамгаалдаг. Учир нь бүхэл бүтэн сүргээ алдах нь оршихуйн цөм, генийн хувьслын хувь заяагаа алдлаа гэсэн үг. Сүргийн тэргүүн азарга залуу азаргануудын байнгын сорилтод байдаг тул түүний амьдрал тулалдааны талбартай адил юм. 2015 онд сүрэг хурааж байсан 10 гаран азарганаас одоо ердөө 7 нь цөөн тоотой жижиг сүргийг тэргүүлж байна. 2019 онд шинээр сүрэг үүсгэсэн зарим азарга сүргээ буцаагаад алджээ. Зарим тохиолдолд нөхцөл байдал бүр ч дордож болно. Энэ оны хоёрдугаар сарын сүүлээр 3 настай Чимбаа нэртэй азарга долоон гишүүдтэй сүргээ “Цуут” хэмээх залууазарганд бүрэн алджээ. Цуут азарга Чимбаа болон түүний төл 2 настай үрээний хамт сүргээсээ хассан ба харамсалтай нь азарга Чимбаа үл мэдэгдэх шалтгаанаар гурван долоо хоногийн дараа үхсэн байна. Магадгүй тэр аль хэдийн өвчтэй эсвэл сул дорой байсан бөгөөд Цуут түүний боломжийг олж харсан байж ч болох юм. Зэрлэг амьтад ярьдаггүй, гэхдээ тэд бие махбодийн хэл, дуу чимээ, үнэрээр нарийн харилцдаг. Сул талууд нь удаан хугацаанд нуугдмал байдаггүй бөгөөд бүрэн ашигладаг.




Эгч дүү тахь Элушка байдас болон (баруун талд) Альфа үрээний хувьд шинэ идээшил нутгийг 2019 онд илрүүлсэн юм. Тэд ДЦГ-ын хилээс зүүн тийш бүрэн гарч Алаг нуурын говь орон, хэдэн сар идээшилж байгаад байгаль хамгаалагч Х.Ганбатаагийн адуун сүрэгт ижилсэн өвөл 2-р сарын сүүлээр Тахийн талдаа эргэж ирсэн байна.



Foto: ©Cyril Ruoso

Сүргийн эзэн азарганы амьдрал тулалдааны талбартай адил юм. Одоогийн 24 үржлийн сүргээс ердөө 7 нь 2015 онд сүрэг хурааж байсан азарганууд байна.



Зүйлийн хөрөг: Идлэг шонхор

Энэхүү хээрийн хүчирхэг шувуутай Мавритан, Австри, Балкан, Араб, хойд Энэтхэг, Хятад-бас Монголд тааралдах боломжтой. Гэхдээ та үнэхээр азтай байх ёстой. Учир нь Идлэг шонхор нь дэлхий даяар нэн ховордсон шувуудын нэг юм¹. Ойрхи Дорнодод шонхор шувууны энэ зүйлийн эрэлт ихэссэнээс, 1980-аад оноос хойш тоо толгой нь ихээхэн буурсан. Өнөөдөр дэлхий даяар ойролцоогоор 10,000 хос өндөглөж, тоо толгой нь хурдацтай буурсаар байна. 1993-2012 оны хооронд тоо толгой нь 50-80 хувиар буурсан бөгөөд энэ хугацаа нь гурван үеийг хамарсан юм!

Энэ зүйлийн махчин шувууг юу ингэж зовоодог вэ? Энэ нь зөвхөн түүний олз олдохгүй байгаатай холбоотой биш. Нугасны хэрийн хэмжээтэй шувууд, зурам зэрэг жижиг мэрэгчид тал хээрийн бүсэд хангалттай нягтралтай хэвээр байна.

Хээр тал өөрөө алга болж байна. Энэ зүйлийн тоо толгойн урдан бууралт нь олон шалтгаантай. Энэ нь шонхор шувууны үүрийг нь ухах, тал хээрийг хөдөө аж ахуйн үржил шимгүй цөл болгох, агрохимийн болон тог цахилгаанд цохиулах зэрэгтэй холбоотой юм.

Идлэг шонхор шувууны цөөн тооны популяц зөвхөн Европт нөхөн сэргэж чадаж байгаа ч Төв Азийн үржлийн бүс, ялангуяа Монгол, Казахстанд эрс буурсаар байгаа ажээ. Тэнд байгаа тоо толгой нь хоёр дахин, цаашид илүү буурсаар байна. Монголд идлэг шонхорыг 2012 онд үндэсний шувуу болгон зарласан хэдий ч цахилгаан гүйдэлд олон мянган залуу шонхор хөнөөгджээ. Мөн хууль бусаар үүрийг нь ухах, ховордсон төрөл зүйлийг худалдаалах тухай (CITES) олон улсын хэлэлцээрийн хүрээнд хуулийн дагуу тооцоо судалгаагүй наймаалцах зэрэг нь шонхорын тоо толгойг цөөрөхөд нөлөөлсөөр байна.

Идлэг шонхор *Falco cherrug* нь хамгийн том, хамгийн хүнд биетэй шонхор шувуудын нэг бөгөөд түүний төрөл зүйлийн нэг болох Цагаан шонхор нь Ойрхи Дорнодод алдартай анч шувуу юм. Тэндхийн шонхор шувуудын хувьд эрлийзжүүлэх замаар генийн санд нь халдаж байна.

Идлэг шонхор нь (томоохон эм шувууны хувьд) 60 см урт, далавчны дэлгэц 120 см хүртэл урттай байдаг.

Идлэг шонхор нь Балкан, Турк болон Ойрхи Дорнод, Төв Азийн нутагт суурин амьдардаг. Гэсэн хэдий ч өвлийн улиралд идэш тэжээлийн хүртээмжээс хамаарч нүүдэллэдэг ба 9-р сараас 5-р сар хүртэл Баруун Сахараас Шар тэнгис, Кени улсаас Сибирийн тайга хүртэлх асар том газар нутгийг хамардаг.

Тэрээр цөлийн зах, заримдаг цөл, тал хээр, хуурай уулархаг нутаг зэрэг задгай газарт ойрхон нисэж агнадаг ба түүний нислэг маш хурдан, хурдаа түргэн авдаг, маш түрэмгий байдаг. Идлэг шонхор нь дунд зэргийн хэмжээтэй жижиг мэрэгч амьтад, мөн хурдан нисдэг жижиг шувуудыг шүүрч барьдаг. Европт саяхнаас мэрэгчдээс гэрийн тагтаа руу шилжсэн байна.

Үүрээ бут сөөг эсвэл хад асганд барьдаг. Дунджаар 3-4 өндөг гаргадаг, үржлийн хувьд олзны нягтралаас ихээхэн хамаардаг бөгөөд энэ нь ялангуяа мэрэгч амьтдын хувьд ихээхэн ялгаатай юм.

Ховордсон зүйлийн улаан жагсаалтад багтсан энэхүү махчин шувууны ирээдүй тийм ч тодорхой бус байна. Ихэнх нүүдлийн шувуудын нэгэн адил (ерөнхийдөө бүх том хэмжээний нүүдлийн шувууд) улс орнуудын хил дамжин амьдарч, олон тооны бэрхшээлтэй тулгардаг тул тэднийг хамгаалахад



Зургийг @ Мухал Гэблер <https://de.m.wikipedia.org>

нэн хэцүү. Гэхдээ сайн, гэрэлтэй талууд бас бий. 2011 онд байгуулагдсан Шонхор шувууны ажлын хэсэг, 2014 онд батлагдсан энэ зүйлийн дэлхий нийтийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь Шонхор шувууг аврах зорилготой бөгөөд Монгол Улс үүнд чухал үүрэг гүйцэтгэнэ. Абу Дабигийн байгаль орчны агентлагийн санхүүжилтээр 5000 гаруй хиймэл үүрийг хийж, 500 хүртэлх үржлийн хос үүрлэх газар санал болгох ёстой. Энэ хөтөлбөр нь 2013 онд 2000 дэгдээхэй болоход хүргэсэн бөгөөд энэ нь шонхор шувуу өсөн үржих итгэл найдвар болжээ.

¹ <https://www.iucnredlist.org/species/22696495/110525916>



Зургийг: Петра Каченский

Зөвхөн цөөн тооны махчин шувууд ногтруунаас хурдан нисдэг. Идлэг шонхор нь тэдний нэг юм. Идлэг шонхорын хувьд ногтруу, зурам, хэрэм түүний идэш болдог.

ТАНЫ ТУСЛАМЖ БИДЭНД ЯАГААД ХЭРЭГТЭЙ ВЭ?

Байгаль хамгаалах ажил нь тийм ч сүр дуулиантай байдаггүй. Ялангуяа дадал болсон ар талын ажлыг амжилттай төсөл болгох нь амаргүй ажил юм.

Тиймээс таны өгсөн хандив тусламжаар хичнээн өөрчлөлт хийж болохыг та эндээс харж болно. Өгч буй хандив бүр бидэнд үнэ цэнэтэй, бид хүлээн авахдаа үргэлж таатай байна.



40,000 төг



120,000 төг



200,000 төг

Та нэг байгаль хамгаалагчийн нэг өдрийн цалин болон түүний ажилдаа хэрэглэх материалыг санхүүжүүлнэ.

Та хяналт шалгалт хийх унааны түлшний савыг түлшээр дүүргэж өгнө.

Та маш ихээр ашигладаг тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг хийхэд хувь нэмрээ оруулна.



300,000 төг



500,000 төг



1 000,000 төг

Та аргаль, янгирт зориулсан нарны эрчим хүчээр ажилладаг худаг хийхэд хувь нэмрээ оруулна.

Та байгаль хамгаалагчийн хяналт шалгалтын сарын ажлыг хэрэгжүүлнэ.

Та 2020 онд хийх Том хөхтөний тооллогын бэлтгэл ажилд тусална.

ОУТГ-ийн гишүүд нь сайн дураар ажилладаг. Бүх хандив тусламж тахийг хамгаалах үйлсэд зарцуулагдах болно.

Та “Тахийн найз нөхөд” болох уу?

- Хувь хүний гишүүнчлэлийн жилийн хураамж **130,000 төгрөг**
- Оюутан, залууст зориулсан “Унага” гишүүний хураамж **50,000 төгрөг**

Хандивын данс

Олон Улсын Тахь Группын Монгол дахь товчоо

499114883 ам. долл.

499248691 төгрөг

Эрхлэн гаргасан

ITG International Takhi Group

Friends of the Wild Horse

c/o Stiftung Wildnispark
Zurich

Alte Sihltalstrasse 38

CH-8135 Sihlwald / ZH

www.savethewildhorse.org

info@savethewildhorse.org

itg.ulaanbaatar@gmail.com



ITG INTERNATIONAL TAKHI-GROUP

Байгаль орчинд ээлтэй цаасан дээр хэвлэв. FSC (Ойн Удирдах Зөвлөл) / EХ Эко шошгоны цаас

